



“БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Огноо 2024.04.29

Дугаар 1/24.

Улаанбаатар хот

Хэзээ: 2024.04.29-ний өдөр 15.00 цагт

Хаана: “Баянгол Ресторан”-ний их танхим /цахим- Facebook live/

Хурлын дарга Б.Аюуш:

Сайн байцгаана уу, та бүхнийхээ амар амгаланг айлтгая. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулах тухай ТУЗ-ын шийдвэрээр ТУЗ-ын дарга Аюуш миний биеийг энэ хурлыг удирдан явуулахаар томилсон байгаа. Эхлээд ТУЗ-ын гишүүн бөгөөд хурал зохион байгуулах комиссын дарга З.Цэрэнчимэг ХЭХ-ын бэлтгэлийг хангах талаар болон хийсэн ажлын тухай та бүхэнд товчхон мэдээлэл хүргэнэ.

ТУЗ-ын гишүүн З.Цэрэнчимэг:

Сайн байцгаана уу, эрхэм хувьцаа эзэмшигчдээ. Хурал зохион байгуулах ажлын хэсэг томилогдож хурлын бэлтгэл ажлыг хангалаа.

Тус компанийн ТУЗ 2024 оны 03 дугаар сарын 19-ний өдөр хуралдаж, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2024 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн 15:00 цагт тус зааланд цахимаар зохион байгуулах шийдвэр гаргасан.

Уг тогтоолоор хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлуудыг баталж, хурал зохион байгуулах комисс, тооллогын комиссыг баталсан.

Хурал зохион байгуулах комисс бэлтгэл ажлын хүрээнд“ ТУЗ-ийн хурлаар батлагдсан “Хувьцаа эзэмшигчдэд танилцуулах хурлын материалаа Монголын Хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороо зэрэг холбогдох газруудад хүргүүлж, 2024 оны 04 сарын 10-наас 2023 оны 04 сарын 29-ний хооронд ,www.bayangolhotel.mn веб сайт BAYANGOL HOTEL фэйсбүүк пейжүүдээр шийдвэр гаргахтай холбогдох материалтай танилцаж, www.bayangolhotel.mn цахимаар саналын хуудсаа ирүүлэх болон хуралд биечлэн оролцож саналын хуудас бөглөх нөхцөлийг бүрдүүлсэн.

Мөн бүртгэлийн өдрийг 2023 оны 04 сарын 08-ний өдрөөр тасалбар болгон хуралд оролцох гишүүдийн бүртгэлийг Үнэт цаасны төлбөр тооцоо хадгаламжийн төвөөс гаргуулан авсан болно.

Хурлын зарыг журмын дагуу “Өдрийн сонин”, “Монголын мэдээ сонин”-д 2024.03,25-ний өдөр болон 2024.04.10-ний өдрүүдэд тус бүр 2 удаа гаргаж, С1 телевизээр хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдах зар явуулж хувьцаа эзэмшигчдэд мэдээллийг хүргэсэн болно.

Өмнөх жилүүдийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар өмнө онуудад гаргасан саналуудын талаар мэдээлж байхыг хүссэн тул зарим мэдээллийг хүргэхээр бэлдсэн.

2023 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар гарсан зарим санал хүсэлтээс дурдвал:

- Хувьцаа эзэмшигч Энхрийлэнгийн аав Жавхлан - Үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ хийлгүүлэхийг зөвлөсөн. Үүнийг 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан болно.
- Ажлын үнэлгээг шинэчлэх тухай ярьсан. 2023 оны 4-р сараас зөвлөх баг авч ажиллуулж, KPI үнэлгээг хэрэгжүүлээд 1 жил болж байна.
- ТУЗ-ын цалинг нэмэгдүүлэх, хариуцлагажуулах тухай цалин хөлсний хороог ахалж ажилласан ТУЗ-ын гишүүн холбогдох судалгааг хийж төсөвт өөрчлөлт оруулсан.
- Хувьцаа эзэмшигч Энхбаяр ноогдол ашиг нэмэгдүүлэх талаар ярьсан ба энэ талаар санхүүгийн тайлан болон холбогдох материалуудад гарах байх. 2024 онд их хэмжээний хөрөнгө оруулалт, засвар шинэчлэлт хийгдэх ба энэ оны ноогдол ашгаа өмнөх оныхоор хэвээр нь өгөхөөр шийдвэрлэсэн ба холбогдох мэдээллээ Санхүүгийн зохицуулах хороо болон хөрөнгийн биржид хүргүүлсэн болно.
- Хувьцаа эзэмшигч Цэвээнравдан хувьцаа эзэмшигчдэд тодорхой мэдээлэл хүргэж байх тухай ярьсан. Олон нийтэд хүргэх мэдээллээ өөрийн пэйж хуудсандаа байрлуулсан байгаа. Монголын хөрөнгийн биржийн санд санхүүгийн тайлан, үйл ажиллагааны тайлан зэрэг бусад холбогдох мэдээллүүд бүгд байршсан байдаг.
- Хувьцаа эзэмшигч Амарсайхан барилгын гадаад өнгө үзэмжийг сайжруулах талаар зөвлөсөн. Үүнийг хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан ба үнийн санал авах, тендер шалгаруулах шатандаа явж байна.

Өнгөрсөн жилийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар гарсан саналуудын талаар дурдлаа.

Одоо та бүхнийг хуралдаа идэвхтэй оролцохыг урьж байна. Ингээд тооллогын комисс ирцийн дүнгээ танилцуулна уу.

Хурлын дарга Б.Аюуш:

Тооллогын комиссын дарга, маркетингийн ахлах менежер Дөлгөөнийг урьж байна. Хурлын ирцийн талаар тооллогын комиссын тогтоолыг танилцуулна.

Тооллогын комиссын гишүүн, маркетингийн ахлах менежер Т.Дөлгөөн:

Сайн байцгаана уу. Баянгол зочид буудал ХК-ны хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комисс хурлын ирцийг та бүхэнд танилцуулж байна. Баянгол зочид буудал ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 31-р хуралд саналын эрхтэй 381,133 ширхэг хувьцаа эзэмшсэн 1058 хувьцаа эзэмшигчдээс 333,222 ширхэг хувьцаа эзэмшсэн хувь нийлүүлэгчид саналаа ирүүлсэн бөгөөд нийт саналын эрхтэй хувьцааны 87,43% төлөөлж байгаа тул компанийн тухай хуулийн 69.1-р зүйл, компанийн дүрмийн 7.4 зүйлийг үндэслэн хурлыг хүчин төгөлдөр тооцож байгааг мэдэгдэж байна.

Хурлын дарга Б.Аюуш:

Дөлгөөнд баярлалаа. Тооллогын комиссын тогтоолоор хурлын ирц хүрсэн учраас хүчин төгөлдөр гэж үзэн хурлаа эхэлье. Хурлын дэгийг хурал хуралдуулах тухай ТУЗ-ын тогтоолоор баталсан. Хурлын дэгийн дагуу Санхүү Хангамжийн албаны дарга Д.Самданжамцыг урьж байна. Компанийн санхүүгийн болон үйл ажиллагааны талаар танилцуулна.

СХА-ны дарга Д.Самданжамц:

Нийт эрхэм хувьцаа эзэмшигчид, гүйцэтгэх удирдлага, ТУЗ, компанийн нийт ажилчдадаа энэ өдрийн мэндийг хүргэе.

2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар мэдээлэл хүргэе.

Баянгол зочид буудал нь 1964 байгуулагдсан, 1991 онд 1058 хувь нийлүүлэгчтэй хувьцаат компани болсон ба 2003 онд 4 одны зэрэглэл авсан үндэсний 100 хувийн хөрөнгө оруулалттай компани юм. 2019 онд ISO9001:2015 ОУ-ын чанарын удирдлагын стандартыг нэвтрүүлсэн дотоодын анхны зочид буудал болсон. 350 орчим зочин хүлээн авах 6 ангиллын 203 өрөө, 300-400 хүн хүлээн авах Баянгол ресторан, үндэсний хоолоор үйлчлэх "Монголын нэг өдөр" ресторан, дээд зэрэглэлийн виноны "Wine house" ресторан, мөн зочдод үйлчлэх дагалдах үйлчилгээтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Компанийн эрхэм зорилго, алсын хараа, зорилтыг тодорхойлж мэргэшсэн, туршлагатай ажилчдыг бэлдэн, зочлохуйн үйлчилгээний салбарт тэргүүлэх чиглэл баримтлан, зочид гийчдийн ая тухтай орчинг бүрдүүлэн тогтмол өсөлттэй ажиллаж байна.

Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдээр 2021-2023 онуудыг харьцуулан үзэхэд тайлант оны нийт хөрөнгийн хэмжээ өмнөх оноос 9,7 хувиар өссөн, нийт орлого өмнөх оноос 32 хувиар, цэвэр ашгийн түвшин 9,5 хувь өссөн бол эздийн өмч орлогын өсөлтийг дагаж 8,07 хувь өссөн үзүүлэлттэй гарсан байна.

2023 оны борлуулалтын орлогыг ангилж үзэхэд нийт орлогын 38,2 хувийг зочид буудлын орлого, 38,3 хувийг рестораны орлого, бусад үйлчилгээний орлого 23,5 хувийг эзэлж байна. Зардлын хувьд нийт зардлын 40 хувийг борлуулсан бүтээгдэхүүний өртөг, 43 хувийг цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, ашиглалтын зардал 7 хувь, урсгал засварт 2 хувь, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал 7 хувь, татварын зардал 1 хувь байна.

2023 онд 1,76 тэрбум төгрөгийн татвар төлсөн байна.

Санхүүгийн тайлангийн шинжилгээг өмнөх онуудтай харьцуулан 7 үзүүлэлтээр шинжлэхэд үзүүлэлт тус бүр хангалттай сайн байна.

2023 онд борлуулалтаа нэмэгдүүлэх чиглэлээр бүтээгдэхүүн, үйлчилгээг сайжруулах талаар өнгөрсөн онд хийж гүйцэтгэсэн ажлууд болон тэмдэглэлт баяр ёслолуудыг алгасалгүй зохион байгуулж өвлийн хөнгөлөлт болон шинэ багцууд гаргасан ба бусад арга хэмжээ, сургалтуудыг зохион байгуулсан.

2023 онд гүйцэтгэсэн хөрөнгө оруулалт, их засварын ажлуудаас дурдахад, "Баянгол ресторан"-ы зүүн хэсэг, Б буудлын нэг давхрын их засвар, оффисын фасад засварын ажил, угаалгын тоног төхөөрөмжийн шинэчлэлтийг хийж дуусгасан.

2024 онд дараах ажлуудыг хийж гүйцэтгэхээр ажлаа эхлээд байна. "Web site" болон "Chatbot" хийлгэх ажил, газрын байгууламжийн шинэчлэлтийн ажил, буудлын гадна фасад засвар, буудлын 20ш өрөөний их засвар, тавилга шинэчлэлт, эйркондейшн суурилуулалт, засварын ажил, Б буудлын давхрын коридорын дотоод засал, галын дохиоллын иж бүрэн шинэчлэлтийн ажил, камержуулалтын системийн шинэчлэлт, буудлын нэг удаагийн болон цагаан хэрэгслийн худалдан авалт, рестораны эдлэл хэрэглэлийн худалдан авалт, гадна талбайн ногоон байгууламжийн тохижилтын ажлуудыг гүйцэтгэж байна.

Хүний нөөц болон ажилчдын нийгмийн асуудлыг дэмжих хүрээнд хийгдсэн ажлуудаас дурдвал, Японы "Heart saving-project" буюу "Зүрх хамгаалах төсөл" ТББ-тай нэгдэн 2008 оноос хойш эмч нарын баг хамт олныг буудалдаа хүлээн авч ажиллаж байна. Энэ жилийн хувьд 67 хүүхдэд зүрхний эхо оношилгоо хийж 14 хүүхдэд катерт эмчилгээ хийсэн. Ажилчдын нийгмийн асуудлыг дэмжих үүднээс жил бүр 1-2 ажилтныг орон сууцны ипотекийн зээлд хамруулж урьдчилгаа төлбөрийг хүүгүй нөхцөлөөр олгож ирсэн ба 2019 оноос хойш 4 ажилтан хамрагдсан байна. Ажилчдын цалин хөлсийг нэмэгдүүлж, урамшуулалт цалингийн системийг нэвтрүүлэн ажиллаж байна. Мөн ажилчдын "Спорт наадам", "Шинэ жилийн арга хэмжээ"-г жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг.

Компанийн засаглалын тухайд, компанийн ТУЗ нь 2022.06.28-ний өдрийн тогтоолын 1 дүгээр хавсралтаар "Баянгол зочид буудал" ХК-ний ТУЗ-ын үйл ажиллагааны журам баталж, уг журмын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна. 2023-2024 онд ТУЗ, түүний хороодын ажиллах журам, компанийн засаглалын журмууд батлах зэрэг компанийн дүрмээр тогтоосон асуудлуудыг хэлэлцэж нийт 8 удаа хуралдаж 18 тогтоол, 6 хурлын тэмдэглэл, 4 журам батлан хэрэгжилтэнд нь хяналт тавьж ажилласан. 2024.02.06-ний өдрийн №4 тоот тогтоолоор нэгж хувьцаанд 300 төгрөгийн ноогдол ашиг олгохоо шийдвэрлэсэн.

2024 оны зорилтуудаас дурдвал:

- Чадварлаг боловсон хүчин, тогтвортой ажлын байр
- Найрсаг харилцаа, тогтвортой харилцагч
- Харилцааны ур чадвар - үйлчилгээний амжилт
- Зочноо дээдэлж, ажилтнаа дэмжин, зочлох үйлчилгээгээр манлайлагч байх
- Төлөвлөө, бүртгэе, хэмнэе
- Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж ажиллах
- Өндөржүүлсэн хяналт, аюулгүй орчныг бүрдүүлэн ажиллах зорилтуудыг тавьж ажиллаж байна.

Хараат бус аудитын тайлангийн дүгнэлтийг танилцуулья. Уг дүгнэлтэнд “Санхүүгийн тайлангууд нь бүх материаллаг зүйлсийн хувьд “Баянгол зочид буудал” ХК-ний 2023.12.31-ний өдрөөр санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болгосон тайлант жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартад нийцүүлэн, Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан журмын дагуу үнэн зөв бодитой тайлагнасан байна” гэж дүгнэсэн юм.

Анхаарал тавьсан та бүхэнд баярлалаа.

Хурлын дарга Б.Аюуш:

Самданжамц даргад баярлалаа. Хувьцаа эзэмшигчид асуух асуулт байвал комментоор ирүүлж болно. Энэ хуралд ТУЗ-ын гишүүд, гүйцэтгэх удирдлагууд, менежерүүд бүгд оролцож байгаа учраас та бүхний асуултанд хариулах боломжтой байна. Одоо гүйцэтгэх удирдлагын тайлантай холбогдуулан ТУЗ-аас гаргасан дүгнэлтийг танилцуулья. 2023 онд борлуулалтын орлогыг 30 гаруй хувь, цэвэр ашгийг 10 шахам хувь өсгөн ажилласан учраас гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааг хангалттай сайн гэж дүгнэлт өгч байна. Мөн компанийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайланд компанийн санхүүгийн байдал, үйл ажиллагааны өнөөгийн байдлыг тайланд бодитой бөгөөд хангалттай сайн гэж дүгнэсэн. Ингээд та бүхний саналаар энэ дүгнэлтийг батлах юм. Одно ТУЗ-ын төсвийг ТУЗ-ын гишүүн Ц.Эрдэнэбат танилцуулна.

ТУЗ-ын гишүүн Ц.Эрдэнэбат:

Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. “Баянгол зочид буудал” ХК-ны ТУЗ-ын 2024 оны зардлын төсөв дараах байдлаар гарсан. Нийт дүн 42,647,300 төгрөг. Үүнээс ТУЗ-ийн гишүүдийн цалин, НДШ зардал-39,825,000 төгрөг, ХЭХ-ын зардал 1,622,300 төгрөг, Хөрөнгийн биржийн хураамж 1,200,000 төгрөг.

Хурлын дарга Б.Аюуш:

ТУЗ-ын зардлын төсвийг батлах тухай саналаа саналын хуудсанд бөглөөд өгсөн учраас тэрүүгээрээ шийдэгдэнэ. Төлөөлөн удирдах зөвлөлийг сонгоно. Энэ жил сонгуулийн жил биш, гэхдээ ТУЗ-ын бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулж байгаа. Кумулятив аргаар ТУЗ-ын гишүүдийг

сонгоход бүрэн бүрэлдэхүүнээр нь бүрэн эрхийг дуусгавар болгож, бүрэн бүрэлдэхүүнээр нь дахиж сонгодог. Дэлгэцэнд ТУЗ-д мэр дэвшигчдийг танилцуулж байна. ТУЗ-н хараат бус гишүүнээр- Б.Аюуш, Б.Саруул, С.Энхтуул, Ц.Эрдэнэбат нарыг нэр дэвшүүлж байна. Ердийн гишүүнээр Х.Баттуул, М.Золжаргал, Б.Намуун, Х.Цэндбаяр, З.Цэрэнчимэг нарыг нэр дэвшүүлж байна. Компанийн сайтанд эдгээр нэр дэвшигчдийн боловсрол болон ажлын туршлагын талаарх мэдээлэл тавигдсан байгаа. Нэр дэвшигчдээс асуух асуулт байвал комментоор ирүүлж болно. Хурлын дэгийн дагуу дараагийн асуудал ноогдол ашиг хуваарлах юм. Самданжамц дарга танилцуулсан байгаа. ТУЗ-ын шийдвэрээр нэгж хувьцаанд 300 төгрөг хувиарлахаар шийдсэн байна.

Одоо тооллогын комисс саналын хуудас тоолно. Саналын хуудаснууд хурал эхлэхээс өмнө ирсэн байгаа.

Тооллогын комиссын гишүүн, маркетингийн ахлах менежер Дөлгөөн:

"Баянгол зочид буудал" ХК-ны хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын тогтоол танилцуулья. Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 заалт, 63 дугаар зүйлийн 63.5 заалт, 67 дугаар зүйлийн 3.8 заалтыг үндэслэн компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ын дүгнэлтийг хэлэлцэн батлах нийт санал 333,222 ширхэг, үүнээс татгалзсан 0, түдгэлзсэн 0, хүчингүй 41, зөвшөөрсөн 333181 санал нь нийт саналын 99,99 хувиар уг шийдвэр хүчин төгөлдөр болж байна. Компанийн ТУЗ-ын 2023 оны зардлын төсвийг батлах асуудлаар нийт өгсөн саналын тоо 333,222, татгалзсан 0, түдгэлзсэн 0, хүчингүй 41, зөвшөөрсөн 333,181 санал нь нийт ирүүлсэн саналын 99,99 хувиар уг шийдвэр хүчин төгөлдөр болсон. Мөн ТУЗ-ын ердийн гишүүнд нэр дэвшигчдийн санал хураах хуудас тоолсон тооллогын комиссын тогтоолоор нэр дэвшигч Х.Баттуул 333,181 санал буюу 99.99 хувь, Б.Намуун 333,181 санал буюу 99,99 хувь, Н.Золжаргал 333,181 санал буюу 99,99 хувь, Х.Цэндбаяр 333,181 санал буюу 99.99 хувь, З.Цэрэнчимэг 333,193 санал буюу 99,99 хувийн санал авч сонгогдлоо. ТУЗ-ын хараат бус гишүүнд нэр дэвшигчдийн санал танилцуулья. Нэр дэвшигч Б.Аюуш 333,181 санал буюу 99,99 хувь, Б.Саруул 333,181 санал буюу 99,99 хувь, С.Энхтуул 333,181 санал буюу 99,99 хувь, З.Эрдэнэбат 333,181 санал буюу 99,99 хувийн саналаар ТУЗ-ын хараат бус гишүүнээр сонгогдсоныг үүгээр мэдэгдэж байна.

Хурлын дарга, ТУЗ-ын дарга Б.Аюуш:

Дөлгөөнд баярлалаа. Хуралаар хэлэлцэх асуудлуудыг хэлэлцэж дууссан тул хурлаас гарах шийдвэрийн тогтоолын төслийг уншиж танилцуулья. Дүгнэлт, төсөв батлах тухайд компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 заалт, хувьцаа эзэмшигчдийн 31-р хурлын тооллогын комиссын 02 тоот тогтоолыг үндэслэн компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ын дүгнэлтийг батлах, компанийн ТУЗ-ын төсвийг батлах, компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 заалт, 77 зүйлийн 77.1 заалт, хувьцаа эзэмшигчдийн

хурлын 31-р хурлын тооллогын комиссын 03 дугаар тогтоолын дагуу ТУЗ-ын ердийн гишүүнээр Х.Баттуул, Б.Намуун, Н.Золжаргал, Х.Цэндбаяр, З.Цэрэнчимэг нарыг, ТУЗ-ын хараат бус гишүүнээр Б.Аюуш, Б.Саруул, С.Энхтуул, З.Эрдэнэбат нарыг томиллоо. Компанийн тухай хууль болон компанийн дүрэм, холбогдох дотоод журмаар тогтоосон бүрэн эрхээ зохих ёсоор хэрэгжүүлж, компанийн эрх ашгийн төлөө мэдлэг чадвараа дайчлан ажиллахыг ТУЗ-ын гишүүдэд хүсье. Өнөөдрийн хурлаар хэлэлцэгдэх асуудлууд бүрэн хэлэлцэгдэж дуусаад тогтоолоо гаргасан тул хурал хүчин төгөлдөр явагдсан гэж үзэн хурлаа өндөрлөө. Хуралд асуулт ирсэн бол хариулъя.

Асуулт: Иргэн Ичинхорлоо Уянга - Яаж бүртгэж байна?

Хурлын дарга, ТУЗ-ын дарга Б.Аюуш: ХЭХ хуралд оролцох саналын хуудас хүлээж авах асуудал бол ТУЗ шийдвэрээр тогтоосноор хурал эхлэх цагаар буюу 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 15:00 цагаар дуусгавар болсон байгаа. Тийм учраас хурлын саналын хуудсыг бол хүлээж авах хугацаа дууссан. Хуралд бол та бүхэн чөлөөтэй лайваар оролцож байгаа, бүртгэх тухай асуудал байхгүй учир 15:00 цагаар бүртгэл тасалбар болсон. Та бүхэндээ баярлалаа, ХЭХ дууссаныг мэдэгдье.

2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 15:55 цагт дууссан.

ХУРЛЫН ДАРГА
ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



Б.АЮУШ
М.АРИУНЗАЯА